

## ӨГҮҮЛЭЛ

# Арктикийн геостратеги: Их гүрнүүдийн тоглолт болон ирээдүйн чиг хандлагын талаарх таамаглал

**Сундуйн Чулуундорж**<sup>ID</sup>

Үндэсний Батлан хамгаалахын их сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс  
[marketpedia.mn@gmail.com](mailto:marketpedia.mn@gmail.com)

**Нямдагийн Ганбат**<sup>ID\*</sup>

Ph.D, профессор  
Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн  
Улаанбаатар, Монгол Улс  
[ganbatn@mas.ac.mn](mailto:ganbatn@mas.ac.mn)

**Хураангуй:** Арктикийн бүс нутагт Евроази ба Хойд Америкийн хойд хэсэг, Хойд мөсөн далай (Норвегийн эргийн арлуудаас бусад), Номхон далай болон Атлантын далайн багахан хэсэг багтана. Арктикийн өмнөд хил нь тундрын бүсийн өмнөд хилтэй давхцана. Энэ бүс нутгийн талбай ойролцоогоор 27 сая кв<sup>2</sup>, зарим баримт бичгүүдэд Арктик нь өмнөд зүгээс хойд туйлын тойрог (66°,33'N)-оор хязгаарлагддаг бөгөөд энэ тохиолдолд түүний талбай 21 сая км<sup>2</sup> байдаг. Соёл иргэний, техник технологийн үсрэнгүй хөгжил, аж үйлдвэржилтийн үр дүнд “Арктик ногоорч” байгаа үзэгдэл нь энэхүү бүс нутгийн байгалийн баялгийг эзэмших боломж харагдахын сацуу умард этгээд дэх далайн усан замуудын шинэ шинэ маршрут нээгдэх болсон нь энэ бүс нутагт хандуулах анхаарал, тухайн бүс нутгийн үнэ цэнэ ач холбогдол өсөн нэмэгдэх нэгэн гол шалтгаан нь болж байна.

**Түлхүүр үгс:** Арктикийн бүс нутгийн аюулгүй байдал, Арктикийн зөвлөл, Их гүрнүүдийн ашиг сонирхол ба тоглолт

\* Corresponding author

© The Author(s), 2025



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<sup>ID</sup> <https://orcid.org/0009-0004-1217-3715>

<sup>ID</sup> <https://orcid.org/0000-0002-9068-1115>

Received: 10 February, 2025

Accepted: 16 June, 2025

Өнгөрсөн зууны эцэс хүртэл Арктик олон улсын харилцааны захад байсаар ирсэн ба цаг уурын хүнд нөхцөл байдал нь АНУ, ЗХУ-ын стратегийн цөмийн хүчний агаарын болон тэнгисийн цэргийн бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагааг эс тооцвол эдийн засгийн хөгжил, цэрэг-улс төрийн бүрэн ажиллагаа явуулахад тохиромжгүй нутаг байв. Олон улсын харилцаа улам бүр олон талт болж өргөжихийн хирээр Арктик ч аажимдаа энэхүү харилцаанд аажим аажмаар татагдан орох болсоны нэгэн илрэл нь Арктикийн орнуудын хүчин чармайлт дор субарктикийн тундрын нутаг дэвсгэр, Хойд мөсөн далайн эргийн зурвасыг хөгжүүлэх стратегийг боловсруулсан байдаг. Харин “Арктикийн гүн” нь хөгжил дэвшлийн нөлөөнд өнөө болтол өртөөгүй, тэр бүү хэл бүрэн судлагдаагүй хэвээр байв. Үүний цорын ганц гэж хэлж болох ач холбогдол нь ЗХУ, АНУ-ын хооронд цөмийн цохилт өгөх хамгийн богино замыг бий болгох явдал байв<sup>1</sup>.

Харин XXI зууны эхэн үед байдал өөрчлөгдсөн. Арктикийн бүс нутаг тэргүүлэх чиглэлүүдийн нэг болжээ. Тухайлбал, нэгдүгээрт, Арктикт ОХУ-ын тэнгисийн цэргийн хүчин болон НАТО-ийн хэд хэдэн гишүүн орнуудын хооронд шууд холбоо байдаг. Хоёрдугаарт, Арктикийн нүүрс устөрөгчийн ордуудын хэмжээ, олборлох ашигт ажиллагааны талаар олон улсын эрдэмтэн судлаачид идэвхтэй ярилцах болсон. Гуравдугаарт, Хойд мөсөн

далайг арилжааны зорилгоор ашиглах боломжийг судлах, юуны түрүүнд дэлхийн дулааралтай холбоотойгоор тээврийн коридор нээх ажил сүүлийн үед хурцаар тавигдах болсон зэрэг шалтгааны учир Арктикийн орон зайг бүс нутгийн хамаарал бүхий улс орнуудын зүгээс харилцан үйлчлэлийн өөрийн гэсэн дүрэм, логиктой бүрэн эрхт бүс нутаг гэж үзэх болжээ. Харин Арктикийг хуваан буй орчин үеийн хуваарилалт XIX-XX-р зууны төгсгөлд Арктикийн орнуудын хоорондох өрсөлдөөний үр дүнд бий болсон түүхтэй. Олон улсын эрх зүйд үүнийг “секторын хуваалт” гэж нэрлэдэг байна. Хойд туйлд нийлдэг хойд хилийн хамгийн баруун ба зүүн цэгүүдээс гарах азимутуудад тулгуурлан Арктикийг туйлын тойргийн орнуудын мэдлийн нутаг дэвсгэрийг зааглан тусгаарлах аргыг хэлнэ. Үүний дагуу 1925 Канад улс эх газрын хойд хэсэгт орших газар нутаг, арлуудыг тус улсын бүрэн эрхт газар нутаг хэмээн мэдэгджээ. Гэтэл 1926 онд ЗСБНХУ-ын Гүйцэтгэх товчооны Тэргүүлэгчдийн шийдвэрээр “Энэ бүс нутагт байгаа бүх газар нутаг, арлууд, нээсэн болон ирээдүйд шинээр нээн илрүүлэх боломжтой бүх газар нь Зөвлөлт Холбоот Улсын нутаг дэвсгэр болно” гэж олон улсад зарлав. Улмаар Дани улс 1933 онд Гренланд дахь эзэмшилдээ түшиглэн Арктикт багахан хэмжээтэй өөрийн гэсэн нутаг дэвсгэр эзэмших болов. 1934 онд Норвеги ч мөн энэ жишгийг дагажээ. Харин АНУ-ын хувьд 1928 онд Аляскийг

<sup>1</sup> М.А.Никулин. Великодержавная конкуренция в Арктике: геополитическое соперничество в новом политическом пространстве. Вестник РУДН. Серия МЕЖДУНАРОДНЫЕ ОТНОШЕНИЯ. 2019. Vol. 19 No. 3 с. 393 <http://journals.rudn.ru/international-relations>

түшиглэн тус бүс нутагт хэмжээгээр хамгийн жижиг нутаг дэвсгэрийн эзэн болов. Үүнтэй холбогдуулан Вашингтон “секторлон хуваах” тогтолцоог хүлээн зөвшөөрдөггүй ч ил тодоор эсэргүүцэж байсангүй.

Арктикийг хяналтдаа авч нөлөөллийн бүс тогтоохын төлөөх өрсөлдөөний түүх нь хэд хэдэн үетэй буюу тэдгээрээс өгүүллийн хүрээнд түүвэрлэсэн байдлаар тоймлон өгүүлбэл:

- XIX зуун. 1873 онд Австрийн туйл судлаач Ж.Пайер, К.Вэйпрехт нар Франц Йозефын газрын архипелагийг нээжээ<sup>2</sup>. 1878 онд Шведийн туйлын судлаач Н.Норденшөльд тэргүүтэй экспедиц Хойд туйлын зүг хөдөлж, Хойд тэнгисийн замыг анхлан мөрлөсөн буюу Хойд мөсөн далайг нэвт дайран гарч, Номхон далайд хүрсэн<sup>3</sup> байдаг.
- 1923–1924 он. Их Британи, АНУ хүч хавсран Хойд мөсөн далайн Сибирийн хэсгийн арлуудыг эзлэх оролдлого хийжээ<sup>4</sup>. 1923-1924 онд АНУ-ын зарим сенаторууд Врангелийн арлыг булаан авахаар лоббидож<sup>5</sup>

байжээ.

- 1924 оноос хойш Норвеги, Дани улсын хооронд Гренландын эрхийн маргаан үүссэн. Норвегичууд Гренландын зүүн эргийг эзэлсэн нь Дани улсын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарав. Ингээд 1932-1933 онд уг маргааныг Гаагийн танхимд хэлэлцэж, Дани улсын талд ашигтай шийдвэрлэсэн<sup>6</sup> ажээ.

1926 онд ЗХУ-ын Төв Хороо “Хойд мөсөн далай дахь газар нутаг, арлууд нь ЗХУ-ын нутаг дэвсгэр гэж зарлах тухай” тогтоол гаргасан. Тогтоолд зааснаар зүүн уртрагийн 320 градус 4 минут 35 секундын өргөрөг ба баруун уртрагийн 168 градус 49 минут 30 секундын меридиан хүртэлх хойд туйл хүртэлх нутаг дэвсгэрийг бүхэлд нь Зөвлөлтийн эзэмшил нутаг гэж зарлав<sup>7</sup>.

Арктикийн төлөөх өрсөлдөөн ЗХУ задран унасны дараах он жилүүдэд ч үргэлжилсэн байдаг. Тухайлбал, 1997 онд ОХУ НҮБ-ын 1982 онд дэвшүүлсэн Далайн эрх зүйн конвенцид гарын үсэг зурав. Хэрэв өмнө нь Арктикийн бүс нутаг бүхэлдээ ЗСБНХУ-ын хууль ёсны өв залгамжлагч болох ОХУ-ын өөрийн зүй

<sup>2</sup> *Tiggesbäumke, Günter*: Mitteilungen. Carl Weyprecht 1838-1881 // Poiarforschung. - 1981. - № 51 (2). - С. 213-218

<sup>3</sup> Österreichisch-Kaiserlicher Hof-Kalender für das Jahr 1875. - Druck und Verlag der K. K. Hof- und Staatsdruckerei, 1875. - С. 119. - 316 с

<sup>4</sup> Hof- und Staats-Handbuch der Österreichisch-Ungarischen Monarchie für 1877. - Druck und Verlag der K. K. Hof- und Staatsdruckerei, 1877. - С. 91. - 1054 с.

<sup>5</sup> Bellot. - Journal d'un voyage aux mers polaires execute a la recherche de Franklin. Paris. 1854. «Вестник НКВД», 1921 г., № 5-6, ст.

<sup>6</sup> Альман. Аксель.- Борьба за северный и южный полюс. Перев. Дьяконовых. Ленинград, 1930 г.; «Tudor Economic Documents», т. II, 1924, pp. 19-23.

<sup>7</sup> А.В.Фененко. Военно-политические аспекты российско-американских отношений в Арктике: история и современность. Вестник Московского университета Серия 25. Международные отношения и мировая политика. 2011.№2. 129-154

Зураг 1. Хойд тэнгисийн зам



Эх сурвалж: Geoidea.ru. “Северный морской путь, интересные факты.” Geoidea — outdoor Интересные статьи. 2024.10.15. <https://geoidea.ru/blog/severnuy-morskoj-put-interesnye-fakty/>

ёсны мэдлийнх гэж байсан бол одоо ОХУ-ын эрх бүхий эзэмшил 12 ба 200 милийн бүсээр хязгаарлагдаж байв.

2015 онд ОХУ-аас НҮБ-ийн Эх газрын тавцангийн хязгаарын комисст (CLCS) өргөдөл гаргасан ч 2019 онд Дэлхийн олон улсын байгууллага Москвагийн талд шийдвэр гаргажээ. Үүний үр дүнд ОХУ-ын мэдлийн Арктикийн усан орон зай 1.2 км<sup>2</sup>-ээр нэмэгдсэн байна.

2010 онд Орос, Норвеги улсууд Баренцийн тэнгис дэх тэнгисийн орон зайг хиллэн зааглах тухай гэрээнд гарын үсэг зурсанаар “саарал бүс” гэх нэр зүүж асан бүс нутагт олон жил үргэлжилсэн зөрчил эцэслэсэн байдаг. Гэвч энэ нь түр зуурын үзэгдэл байсан нь сүүлийн үед өрнөж буй үйл явдлууд харуулна.

Эдийн засгийн хувьд үсрэнгүй хөгжихийн сацуу олон улсын тавцанд өөрийн байр сууриа улам бүр тод, хүчтэй илэрхийлэх болсон БНХАУ хөгжлийн стратегиа “Бүс ба Зам” санаачилга нэртэйгээр зарлаж,

“Арктикт ойрхон улс” гэсэн ойлголтыг бий болгож энэ хүрээнд ОХУ-тай хамтран “Мөсөн далайн торгоны зам” төсөл хэрэгжүүлэх болсноор Арктикийн зөвлөлийн гишүүн орнуудад энэ бүс нутгийн аюулгүй байдлыг эргэн харах шаардлагатай болсныг анхааруулж, магадгүй түгшүүрийн харанга дэлдэх нөхцөл ч үүссэн байж болно. Олон улсад өрнөж буй үйл явдлаас үзвэл ойрын ирээдүйд Их гүрнүүдийн чухам хэн нь эсвэл ямар эвсэл дэлхийд тэргүүлэх байр суурьтай болохыг шийдэх гол тоглолт чухамдаа энэ бүс нутагт өөрийн нөлөөллөө тогтоох эсэхээс хамаарч болзошгүй мэт. Олон улсыг тэргүүлэх, өөрийн нөлөөллөө батжуулан бэхжүүлэх, харьяаллын бүсээ тогтоохын төлөөх их өрсөлдөөн идэвхжихийн хирээр Их гүрнүүд тус бүс нутагт анхаарлаа хандуулан, өөр өөрийн стратегиа дахин тодорхойлж эхэлсэн нь цаашид энэ бүс нутаг олон улсын анхаарлыг татсан нэгэн халуун цэг болохыг үгүйсгэх аргагүй.

Зураг 2. Арктикийн бүс нутаг



Эх сурвалж: Central Intelligence Agency, *The World Factbook: Russia*, last updated June 10, 2025, <https://www.cia.gov/the-world-factbook/countries/russia/>.

АНУ-ын 47 дахь Ерөнхийлөгч Дональд Трамп өөрийн “Truth” нийгмийн сүлжээнд 2024 оны 12 сарын 20-нд “олон арван канадчууд АНУ-ын 51 дэх муж болохыг хүсэж байна” гэж мэдэгдсэн бол мөн сарын 21-нд АНУ-ын хөлөг онгоцуудад Панамын сувгийг ашиглах хураамжийг бууруулахгүй бол тус сувгийг дахин хяналтандаа авахыг сануулаад сувгийг “буруу гарт” орохоос сэргийлнэ гэсэн бол мөн тус сарын 23-нд Кен Хоуриг Дани улсад суух Элчин сайдаар томилох тухай зарлахдаа, АНУ-ын Үндэсний аюулгүй байдал, даян Дэлхийн эрх чөлөөг хангах үүднээс Гренландыг эзэмших, хянах нь зайлшгүй шаардлагатай гэж онцлон тэмдэглэв.

АНУ-ын 47 дахь Ерөнхийлөгч Дональд Трампын ийнхүү дараалсан мэдэгдлүүд нь олон улсын анхаарлыг эрхгүй татаж, холбогдох улс орнууд

үүнд хариу үйлдэл үзүүлж эхлэв. Тэр дундаа АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампын онцлон дурдсан “буруу гар”-ын тухай мэдэгдэл нь эрхгүй анхаарал татна.

БНХАУ-ын дарга Си Жиньпин 2018 онд Панамд төрийн айлчлал хийж хоёр улсын хооронд хэд хэдэн хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурсан нь “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд Панамын сувгийн бүс нутагт өөрийн нөлөөгөө бэхжүүлэх зорилго агуулсан алхам болов уу. Энэ нь БНХАУ-ын оролцоо далайн боомт, логикийн дэд бүтцэд хийж буй их хэмжээний хөрөнгө оруулалтаар илэрхийлэгдэх мэт. Ялангуяа, Хятадын төрийн өмчит компаниуд Панамын сувгийн хоёр үзүүрт байрлах боомтуудын үйл ажиллагааны эрхийг гартаа оруулсан нь тус бүс нутаг дахь БНХАУ-ын стратегийн байр суурийг

илэрхийлэн буй чухал баримтуудын нэг гэсэн дүгнэлт рүү эрхгүй хөтөлнө<sup>8</sup>.

БНХАУ нь хэдийгээр газарзүйн хувьд далайд гарцтай боловч Зүүн Хятадын тэнгис болон Өмнөд Хятадын тэнгис нь АНУ-ын холбоотон болох Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг улс, нутаг орны хяналтанд оршдог. Энэ нь Хятадын далайд гарах чөлөөт байдлыг хязгаарлах хүчин зүйл болох учир БНХАУ стратегийн шинэ гарцууд эрэлхийлсэн алхам хийхэд хүргэж байна<sup>9</sup>.

2018 онд БНХАУ-ын зүгээс боловсруулсан “Арктикийн бодлого” нь тухайн бүс нутагт нөлөөгөө тогтоох, “хамтран хөгжих” зарчим баримтлах стратегийн зорилго<sup>10</sup> тавьж Дани улсын автономит бүс нутаг Гренландад хөрөнгө оруулалт хийх болсон бөгөөд Гренландын газрын ховор элементийн орд газар, тухайлбал “Кванефельдийн орд”-ын төслийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх болсон. “Шенхе ресурс” компани нь Гренландын “Минералс компани”-аас 12.5 хувийн хувьцааг нь худалдаж авсан бөгөөд энэ нь БНХАУ-ын газрын ховор элемент болоод уран олборлохтой холбоотой эдийн засгийн ашиг сонирхлыг нь илэрхийлж байна<sup>11</sup>.

Цухас дурдсанчлан БНХАУ “Арктикийн бодлого” баримт бичигтээ “БНХАУ бол Арктикийн ойролцоо орон” гэж тодорхойлоод энэ бүс

нутагт өөрийн зүгээс эдийн засгийн болон геополитикийн оролцоогоо нэмэгдүүлэх алхам хийв. Харин үүнийг нь Арктикийн зөвлөлийн байнгын гишүүн орнууд болох АНУ, ОХУ, Канад, Финлянд, Исланд, Норвеги, Швед зэрэг улсууд анхааралтай бас болгоомжтой ажиглаж байна<sup>12</sup>.

Өгүүлэн буй бодлогын хүрээнд Бээжин “Мөсөн торгоны зам” хэмээх шинэ нэршил бүхий төсөл дэвшүүлсэн байдаг. Арктикийн бүс нутгаар дамжин өнгөрөх шинэ далайн тээвэр, худалдааны сүлжээг хөгжүүлэх төсөл нь БНХАУ-ын эдийн засгийн стратегийн нэг хэсэг нь болно. Энэхүү төслийн үндсэн зорилго нь Хойд мөсөн далайн усан замыг ашиглан Европ, Ази, Хойд Америкийн хооронд тээврийн шинэ гарц нээх явдал болов уу. Ташрамд өгүүлэхэд, Арктикийн далайн усан зам нь уламжлалт Маллакийн хоолой, Суэцийн сувгаар дамжих маршрутаас 40% богино гэдгээрээ онцлогтой. Энэ нь Хятад, Орос, Европ хоорондын тээврийн хугацаа болон зардлыг бууруулах стратегийн чухал ач холбогдолтой маршрут болно<sup>13</sup>. Харин энэ төсөл нь НАТО болон АНУ-ын анхаарлыг ихээхэн татаж, Арктикийн бүс нутаг дахь их гүрнүүдийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна<sup>14</sup>.

2017 онд энэхүү төслийн хүрээнд

<sup>8</sup> Méndez, F., & Alden, E. (2019). *China in Panama: From Peripheral Diplomacy to Grand Strategy*

<sup>9</sup> Cordesman, A. H. (2019). *China's Maritime Strategy and Security*. CSIS.

<sup>10</sup> Rolland, N. (2017). *China's Arctic Ambitions and the Implications for Global Geopolitics*. *The National Bureau of Asian Research*, 38(2), 99-118.

<sup>11</sup> Méndez, F., & Alden, E. (2019). *China's Growing Presence in Greenland and the Arctic: Strategic and Economic Interests*. *Global Affairs Journal*, 22(3), 45-61.

<sup>12</sup> Brady, A. (2017). *China as a Polar Great Power*. Cambridge University Press.

<sup>13</sup> Humpert, M. (2020). *China's Polar Silk Road and the Arctic Geopolitics*. *Arctic Yearbook*, 2020, 67-88.

<sup>14</sup> Pincus, R., & VanderZwaag, D. (2018). *Arctic Geopolitics and International Relations: The Future of*

БНХАУ болон ОХУ хамтран хөгжүүлэх гэрээ байгуулж, Оросын Арктикийн далайн замыг өргөжүүлэхээр хоёр тал тохиролцсон байдаг. Энэхүү харилцан ойлголцолд тулгуурласан тохиролцооны үр дүнд ОХУ-ын Ямалын хойгт байрлах байгалийн хийн томоохон орд газрыг ашиглах төслийг БНХАУ-ын “CNPC” болон “Silk Road Fund” хамтран санхүүжүүлэх болсон. Үүнээс харахад БНХАУ Ямалын байгалийн хийг худалдан авч, Арктикийн замаар тээвэрлэхийг сонирхож байгаа<sup>15</sup> бололтой. Хэдийгээр ОХУ “Мөсөн торгоны зам” төслийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах ашиг сонирхолтой байгаа ч Москва, Бээжингийн Арктикт давамгайлах хүсэл эрмэлзэлд болгоомжтой хандаж байгаа<sup>16</sup> болов уу. Сэдвийн хүрээнд хөндөн буй Арктик нь ОХУ-ын хувьд стратегийн чухал бүс нутгийн нэг бөгөөд өөрийн газар нутгийнхаа 40 орчим хувийг Арктикийн тойрогт хамруулдаг. Мөн тус улс нь Арктикт хамгийн урт эргийн шугамтай. Тиймдээ ч, Арктикийн гишүүн орнуудын дунд төдийгүй олон улсын тавцанд энэ бүс нутгийн байгалийн баялагт хүрэх, энэ бүс нутгаар дайран өнгөрөх далайн тээвэр, энэ бүс нутгийн цэргийн аюулгүй байдал зэрэг стратегийн чухал чиглэлүүдэд

тэргүүлэх байр суурьтай хэвээр байна. Нэмж өгүүлэхэд, Арктик нь газрын гүндээ дэлхийн байгалийн хийн 30 хувь, нефтийн 13 хувийг агуулдаг ба ОХУ-ын эрчим хүчний гол эх үүсвэр чухам энэ бүсэд байна<sup>17</sup>.

ОХУ-ын Засгийн Газар 2020 онд “Арктик- 2035” стратегийг баталж, тус бүс нутаг дахь өөрийн цэргийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх зорилт тавьсан байдаг. Дэвшүүлсэн зорилтын хүрээнд ОХУ Арктикт 50 гаруй цэргийн бааз, 40 гаруй нисэх онгоцны буудал, радарын шинэ станц 13 байгуулаад зогсохгүй хойд флотоо бие даасан цэргийн тойрог болгон өргөтгөсөн<sup>18</sup> бол саяхан буюу 2025 оны гуравдугаар сарын 25-нд Хойд мөсөн далайн цэргийн флотод зочилж

«Архангельск» 885М «Ясень-М» – хэмээх дөрөв дэх үеийн олон талт ажиллагаа явуулах чадвартай цөмийн шумбагч онгоцтой танилцсан бол өмнөх нь цөмийн «Ясень» бүлгийн 885/885М төслийн «Пермь» шумбагч крейсериин нээлтийн ёслолд цахимаар оролцсон<sup>19</sup> байдаг. Түүнчлэн, ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Арктикийн олон улсын форумд оролцохдоо ОХУ-ын Засгийн газарт Хойд мөсөн далайн флотын дэд бүтцийг хөгжүүлэх төсөл боловсруулахыг үүрэг болгохын сацуу

*Cooperation in a Changing Region. Arctic Review on Law and Politics, 9(2), 23-45.*

<sup>15</sup> Liu, N., & Wilkman, A. (2021). *China's Role in Arctic Energy Development*. *Energy Policy, 147*, 112-128.

<sup>16</sup> Konyshv, V., & Sergunin, A. (2021). *Russia's Arctic Strategy: Military and Political Dimensions*. *The Journal of Eurasian Studies, 12(1)*, 55-72.

<sup>17</sup> Humpert, M. (2020). *Russia's Arctic Strategy and the Future of the Northern Sea Route*. *Arctic Yearbook, 2020*, 45-68.

<sup>18</sup> Pincus, R. (2018). *Three-Way Power Struggle: The US, Russia, and China in the Arctic*. *Arctic Review on Law and Politics, 9(2)*, 45-63.

<sup>19</sup> [www.kremlin.ru/events/president/news/76556](http://www.kremlin.ru/events/president/news/76556) Спуск на воду атомного подводного крейсера «Пермь». Президент России

тус бүс нутаг дахь ОХУ-ын зорилго нь “түүхэн цар хүрээтэй” байх ёстойг онцлон тэмдэглэсэн<sup>20</sup> нь эрх биш нэгийг бодогдуулах буй заа.

ОХУ-ын хэрэгжүүлэн буй “Ямал LNG” болон “Арктик LNG-2” төслүүд нь тус улсын байгалийн хийн экспортын гол тулгуур бөгөөд энэхүү төслүүддээ БНХАУ болон Франц, Япон зэрэг улсуудаас хөрөнгө оруулалт татаж чадсан байдаг. Ялангуяа, “Ямал LNG” төслийн нийт санхүүжилтийн 20 хувийг “CNPC”, 9.9 хувийг “Silk Road Fund” санхүүжүүлж буйгаас харахад энэ бүс нутагт Москва, Бээжингийн хамтын ажиллагаа өсөн нэмэгдэж байгаа нь тодорхой байна<sup>21</sup>.

Нэмж өгүүлэхэд, ОХУ нь 2035 он гэхэд Хойд тэнгисийн мөсөн замаар дамжих тээвэрлэлтийг 100 сая тонн хүргэх зорилго тавьсан<sup>22</sup>.

2021 онд ОХУ Хойд мөсөн далайн ёроолд орших 1600 км урттай, 2000-4000 м гүнд байрлах асар их байгалийн баялаг бүхий Ломоносовын нурууг өөрийн эх газрын үргэлжлэл гэж үзэхийн учир өөрийн улсын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг мөн болохыг олон улсад батлан зөвшөөрүүлэх зорилго дор 2015 оны шинэ судалгааны үр дүнг үндэслэн 1.2 сая км.кв газар нутгийг өөрийн эзэмшилд багтаах

хүсэлтээ НҮБ-ын тэнгисийн эрх зүйн конвенц буюу UNCLOS-ийн дагуу өргөн мэдүүлсэн байдаг<sup>23</sup>.

2021 онд НАТО “Арктикийн бүс дэхь Оросын цэрэг, улс төрийн нөлөөлөл нэмэгдэж байгааг цохон тэмдэглэж байсан бол 2022 онд ОХУ-ын Украинд явуулсан ЦТА (цэргийн тусгай ажиллагаа, цаашид “ЦТА” гэх)-ны улмаас Арктикийн зөвлөлийн гишүүд ОХУ-тай хэрэгжүүлж асан аливаа хамтын ажиллагаагаа зогсоосон байдаг<sup>24</sup>.

Арктикийн бүс нутгийн байгалийн баялгийн судалгаа сэдвийг эргэн сөхөж гэмээ нь, 2014 онд Дани улс НҮБ-т Ломоносовын нуруу нь Гренландын эх газрын үргэлжлэл гэж нотолсон судалгааны үр дүнг танилцуулсан байдаг. Дани Улс нь Гренландын ард түмний өөртөө засах эрхийг хамгаалах бодлого баримтлахын сацуу энэ бүс нутагт өөрийн нөлөөллөө хадгалахыг зорьж байна<sup>25</sup>.

Дани Улс 2020 онд Арктикийн талаар баримтлах шинэ стратегиа зарлаж, үүндээ бүс нутгийн байгаль орчны хамгаалалт, уур амьсгалын өөрчлөлтөд анхаарлаа хандуулах бодлого баримтлах болов. Үүний сацуу Дани Улс нь НАТО-ийн хүрээнд АНУ-тай хамтран ажиллаж Гренланд

<sup>20</sup> www.Kremlin.ru/events/president/news/76556 Спуск на воду атомного подводного крейсера «Пермь». Президент России

<sup>21</sup> Gabuev, A. (2020). *Sino-Russian Relations and Arctic Governance: Cooperation or Competition?* Carnegie Moscow Center.

<sup>22</sup> Konyshchev, V., & Sergunin, A. (2021). *Russia's Arctic Strategy: Military and Political Dimensions*. The Journal of Eurasian Studies, 12(1), 55-72.

<sup>23</sup> Konyshchev, V., & Sergunin, A. (2021). *Russia's Arctic Strategy and International Territorial Disputes*. The Journal of Eurasian Studies, 12(1), 45-67.

<sup>24</sup> Lanteigne, M. (2022). *Arctic Geopolitics after Ukraine: Russia's Role and Western Responses*. Polar Journal, 10(2), 102-121.

<sup>25</sup> Lanteigne, M. (2019). *The Politics of Arctic Sovereignty: Oil, Ice, and Inuit Governance*. University of Toronto Press.



дахь цэргийн хяналтаа чангатгахын зэрэгцээ “Туле” (*Thule Air Base*)<sup>26</sup> агаарын цэргийн баазыг байрлуулсан нь Арктикийн агаарын хамгаалалт, пуужингийн довтолгооноос хамгаалах системийн нэгэн бүрдэл хэсэг нь болсон ажээ.

Мөн 1973 оноос эхэлсэн Дани болон Канадын зүгээс Арктикийн хил тогтоох маргаан Хансын арал дээр үүсэж, тодорхой шийдэлд хүрэхгүй байсаар 2022 онд хоёр тал уг арлыг тэнцүү хэсэгт хуваан эзэмших тухай албан ёсны гэрээ байгуулсан нь НАТО-ийн эв нэгдлийг харуулсан чухал үйл явдал болсон гэдэг.

Хойд мөсөн далайн усан замын нэг хэсэг болох хойд баруун зам (North west passage) сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа нь дэлхийн цаг уурын дулааралтай холбоотой бөгөөд Канад Улс энэхүү усан замыг өөрийн дотоод усан зам гэсэн байр суурь нь АНУ болон Европын Холбооны энэхүү усан замыг олон улсын чанартай усан зам гэсэн бодлоготой зөрчилддөг ажээ<sup>27</sup>.

ОХУ Арктикт цэргийн хүчин чадлаа нэмэгдүүлж, шинэ баазууд

барьж байгаа нь Канадын үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлж байгаатай холбоотойгоор НАТО, АНУ-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хамтран хамгаалах бодлого хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай тулгараад байгаа<sup>28</sup> боловч энэ нь АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп ба түүний Засгийн газрын цаашид баримтлах бодлого зэргээс шууд хамаарах төлөвтэй байна.

БНХАУ-ын “Мөсөн торгоны зам” бодлогын хүрээнд Канадын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхтэй зэрэгцэн тус улсын нутаг дэвсгэр дэх газрын ховор элементийг олборлох ашиг сонирхолоо илэрхийлж байгаа нь Канадын Засгийн Газрын анхаарлыг ихэд татах болжээ<sup>29</sup>. Иймээс Канад улс 2019 онд “Канадын Арктикийн суурь стратеги”-ийг боловсруулж энэхүү стратегийн хүрээнд нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалах, экосистемийг хамгаалах бодлого хэрэгжүүлж байна.

ОХУ болон БНХАУ-ын Арктикийг эзэмших эрчимтэй бодлогыг олон улс анхааралтай ажиглаж байгаа бол ОХУ-ын сөрөн зогсож буй НАТО

<sup>26</sup> Питуффик сансрын бааз (*Pituffik Space Base* хуучнаар Тулегийн агаарын бааз; IATA: THU, ICAO: BGTL) нь Гренландын хойд хэсэгт байрладаг АНУ-ын сансрын бааз бөгөөд Каасуицуп хотын нутаг дэвсгэрт байрладаг боловч түүний нэг хэсэг биш бөгөөд Гренланд мэдлийн бус нутаг дэвсгэр. Thule агаарын бааз нь Хойд туйлын тойргоос хойд зүгт 1118 км, хойд туйлаас 1524 км зайд оршдог АНУ-ын хамгийн хойд этгээд дэх алслагдсан цэргийн бааз. Агаарын бааз байрлахаас өмнө тус газар нутгийн уугуул иргэд болох эскимосчуудын Уумманнак болон Питуффик хэмээх суурингууд байсан бөгөөд бааз барихтай холбогдуулан 1953 онд оршин суугчдыг нь Каанаак хотод нүүлгэн шилжүүлсэн байна. Агаарын бааз дахь Питуффик суурингийн байнгын хүн ам 2009 оны 1-р сарын байдлаар 166 хүн байжээ (<https://ru.wikipedia.org/wiki>)

<sup>27</sup> Byers, M. (2021). *International Law and the Northwest Passage: Canada's Legal Position and Global Reactions*. *Journal of Arctic Affairs*, 8(3), 102-120.

<sup>28</sup> Huebert, R. (2020). *Canada and the Arctic: NATO, NORAD, and the Growing Security Challenges*. *Canadian Foreign Policy Journal*, 27(2), 89-105.

<sup>29</sup> Lanteigne, M. (2020). *China's Emerging Role in the Arctic: The Polar Silk Road and its Implications for Canada*. *Polar Journal*, 9(1), 78-95.

болон АНУ-ын хамтын ажиллагаа ч эрчимжих төлөвтэй байна.

Хэдийгээр Финлянд Улс экологийн тогтвортой байдал бий болгох тухайд эрчимтэй ажиллаж, Арктик ба Европыг холбосон дэд бүтцэд анхаарлаа хандуулахын сацуу Европын уур амьсгалд ээлтэй эдийн засагтай улс болох зорилт тавьж 2035 он гэхэд нүүрстөрөгч ялгаруулах эрчим хүчний төвийг сахьсан улс болох зорилго тавьсан байдаг. Үүний сацуу Финлянд Улс Арктик дахь ОХУ болон БНХАУ-ын хамтын үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлж байна гэж үзсэний улмаас, ялангуяа Украинд “Цэргийн тусгай ажиллагаа” буюу олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бичсэнээр Украинд хийж буй дайны улмаас 2023 онд НАТО-д элсэж, төвийг сахьсан байр сууриа өөрчлөн Арктикийн Аюулгүй байдлын стратегиа шинэ түвшинд гаргаж ирсэн. Өмнөх стратегийн шалтгааны улмаас 2023 онд Швед улс НАТО-д элсэж төвийг сахьсан байр сууриасаа татгалзаж, Арктик дахь ОХУ-ийн нөлөөллийг хязгаарлахын тулд Швед, Финлянд-Норвегийн цэргийн хамтын ажиллагаа буюу хамтарсан батлан хамгаалахын бодлого хэрэгжүүлж эхлээд байна. Швед Улсын хойд нутаг (Norrbotten, Västerbotten) нь Арктикийн бүс нутагт хамаардаг. Тиймээс, Швед улсын Засгийн Газраас 2020 онд “Шведийн Арктикийн стратеги”-ийг шинэчлэн батлаж, стратегийн хүрээнд

эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаас гадна Аюулгүй байдлын хүрээнд НАТО, АНУ, Арктикийн зөвлөлийн орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, уугуул иргэд буюу Сами үндэстэний эрх ашгийг хамгаалах бодлого соёрхон баталжээ. Швед Улс нь Арктикийн бүс нутагт төмрийн томоохон ордуудтай ба тус улсын “LKAB компани” нүүрстөрөгчгүй ган үйлдвэрлэх технологиор олон улсад тэргүүлж байна. Мөн сэргээгдэх эрчим хүчний салбарт Салхины эрчим хүч, устөрөгчийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ Арктикийн бүс нутгийн сансар, уур амьсгалын судалгааны гол төв (Esrange Space Center)-ийг байгуулсан<sup>30</sup>.

Харин Исланд Улсын хувьд Арктикийн бүс нутагт далайн тээвэр, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүч, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр эрчимтэй ажилладаг<sup>31</sup>. Исланд Улс нь өөрийн цэрэггүй статусыг хадгалж, НАТО-ийн гишүүн орон байдлаар Арктикийн аюулгүй байдлын бодлогоо тодорхойлдог. Нэмж өгүүлэхэд, Исланд Улс нь Арктикийн зөвлөлийн үүсгэн байгуулагч бөгөөд 2021 онд Арктикийн бодлогын шинэ стратегиа баталсан. Энэхүү стратегийн хүрээнд эдийн засгийн өсөлт ба тогтвортой хөгжил, шинжлэх ухаан ба инноваци, аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлого, чиглэлийг тусгасан<sup>32</sup> байна.

<sup>30</sup> Lindahl, K. (2021). *Mining, Sustainability, and Sweden's Arctic Policy*. *Journal of Arctic Studies*, 15(2), 78-92.

<sup>31</sup> Ingimundarson, V. (2020). *Iceland and Arctic Geopolitics: Economic Interests and Security Challenges*. *Journal of Arctic Affairs*, 17(2), 89-104.

<sup>32</sup> Government of Iceland. (2021). *Iceland's Arctic Policy: Sustainable Development and Security in the Arctic Region*. Ministry for Foreign Affairs.

Түүхийн хуудас сөхвөл, Хойд Атлантын болон Арктикийн бүс нутгийн Аюулгүй байдлыг хангах зорилготой стратегийн чухал үүрэг гүйцэтгэх шийдвэрийн хүрээнд 1951 онд АНУ болон Исландын Засгийн газар Батлан хамгаалахын хоёр талт гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсны үндсэн дээр Кефлавик дахь АНУ-ын цэргийн баазыг байгуулсан байдаг. Энэхүү цэргийн бааз байгуулагдсан явдал нь Арктикийн бүс нутаг дахь НАТО-ийн аюулгүй байдлыг хангах, Хойд Атлантад хяналт тогтоох нэгэн гол цэг нь болж Хойд Америк болон Европын батлан хамгаалах гол холбогч нь болохын сацуу Оросын цэргийн флотын үйл ажиллагааг харьцангуй ойрхон зайнаас хянах гэх зэрэг стратегийн чухал үүрэг гүйцэтгэх болов.

Сүүлийн үед олон улсын тавцанд өрнөж буй үйл явдал зэргээс үзвэл АНУ-ын зүгээс дэлхийн жанжлагч гүрний байр сууриа хэвээр хадгалах уу, эсвэл алдах уу гэдгээ шийдвэрлэх чухал цаг үетэй нүүр тулаад байгаа бөгөөд мөнхийн “түнш” буюу өрсөлдөгчид нь болох ОХУ-аас гадна сүүлийн үед олон улсын тавцанд өөрийн байр сууриа улам бүр хүчтэй илэрхийлэх болсон БНХАУ гэсэн хоёр улс хамтран Арктикийг эзэмших өрсөлдөөнд ялах, улмаар тэргүүлэх байр сууриа батжуулан бэхжүүлж өөрийн нөлөөллөө тогтоох бодлогыг нь хязгаарлахад ихээхэн хүчин чармайлт гаргах нь ойлгомжтой болоод байна.

Арктик дахь ОХУ-ын цэргийн идэвхжилт болон олон улсын тавцанд

улам бүр хүчээ авч буй БНХАУ-ын эдийн засгийн нөлөө тус нутагт улам бүр нэмэгдэж байгаатай зэрэгцэн АНУ-ын Арктик дахь аюулгүй байдлын ашиг сонирхол, оролцоо ч мөн эрс нэмэгдэж байна. АНУ-ын Батлан хамгаалах яамны 2019 оны Арктикийн талаар баримтлах стратегид уг бүс нутагт цэргийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, гэнэтийн болон алсдаа үүсч болохуйц нөхцөл байдалд бэлтгэлтэй байх, хурдан хариу өгөх чадварыг сайжруулах зорилт тавьсан<sup>33</sup> байдаг. Энэхүү стратегид АНУ-ын Арктикийн бүс нутаг дахь стратегийн ач холбогдол бүхий хэд хэдэн цэргийн бааз хамрагдсан.

Үүнд:

1. Thule Air Base – Гренландад байрлах энэхүү бааз нь АНУ-ын сансар огторгуйн хяналт, пуужингийн довтолгооноос хамгаалах системийн гол цэгүүдийн нэг болно.
2. Eielson Air Force Base – F-35 сөнөөгч онгоцны байрлах нэгэн чухал төв бөгөөд тус онгоцны тусламжтайгаар Арктикийг бүхэлд нь хянах, шаардлагатай тохиолдолд өрсөлдөгч талдаа өрсөж цохилт өгөх, довтлох чухал стратегийн цэг юм.
3. Joint Base Elmendorf-Richardson – АНУ-ын хойд командлалын хүрээнд ажилладаг, Арктикийн бүсэд хяналт тавих үүрэгтэй цэргийн бааз болно.

Үүнээс гадна АНУ-ын Ерөнхийлөгчийн албыг дахин хаших болсон Дональд Трамп 2019 онд

<sup>33</sup> Department of Defense. (2019). *Arctic Strategy*. U.S. Department of Defense.

Дани улсад Гренландыг худалдаж авах санал тавьсан ч татгалзсан хариу авсан нь АНУ-ын Арктикийн геополитикийн ашиг сонирхол ихсэж байгааг харуулсан бас нэгэн жишээ болов уу. Хэдийгээр тухайн үед энэ “хачирхалтай” санал няцаагдсан ч АНУ Гренландийн талаархи ашиг сонирхолоо орхиогүй бөгөөд 2025 онд АНУ тус улсад өөрийн Консулын газраа нээж, Консул томилсон явдал нь хоёр улсын дипломат харилцаа шинэ шатанд гарсан хийгээд хоёр улсын хооронд явагдаж буй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нэгэн том алхам болсноос гадна бүс нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах, батжуулах тухайд илүү өргөн хүрээнд илүү эрчимтэй хамтран ажиллах зорилго тавьж буйн

илрэл болов уу.

Дональд Трампын Засгийн газар Парисын уур амьсгалын гэрээнээс гарахаа зарлаж, дэлхийн дулаарлын эсрэг хүлэмжийн хий бууруулах үйл ажиллагаанд оролцохгүй болсон нь Арктикийн зөвлөлийн үйл ажиллагаатай зөрчилдөж байгаа хэрэг болно.

АНУ нь 2013 онд Арктикийн үндэсний стратегийг батлаж, 2022 онд шинэчлэн баталсан. Уг баримт бичигт тус бүс нутгийн аюулгүй байдал, байгалийн баялгийг тогтвортой ашиглах бодлогыг дэмжих зорилтуудыг тусгасан бөгөөд Арктикийн бүс нутагт өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр АНУ өөрийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага урган гарч ирсэн учир шинэчлэн баталсан байдаг<sup>34</sup>.

### Дүгнэлт

Орчин үед хиймэл оюун ухаан, аж үйлдвэржилт, цэрэг, техник, технологийн салбарын үсрэнгүй хөгжил нь хүн төрлөхтөн сансар огторгуй хийгээд далайн гүнийг эзэмших боломжийг олгож байгаа хэдий ч, эдийн засгийн хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээг хэрхэн хангах вэ гэсэн чамгүй ээдрээтэй асуудалтай нүүр тулж байна.

Арктикийн бүс нутагт өөрийн нөлөөллөө тогтоох, стратегийн ашигтай байрлал эзлэхийн төлөөх Их гүрнүүдийн тоглолт 2013 он хүртэл идэвхигүй, “унтаа” шахуу байдалтай явж байсан бол үсрэнгүй хөгжлийн гайхамшигийг үзүүлсэн БНХАУ “Бүс ба зам” санаачилгын хүрээнд эдийн

засгийн цар хүрээгээ тэлэх, далайн усан замын тээврийн гарцтай болох зорилго дор өөрийн улсаа “Арктикт ойрхон улс” гэж тодорхойлсон тэр л үеэс энэхүү бүс нутгийн аюулгүй байдал олон улсын анхаарлыг соронзон мэт татах болж өрсөлдөөний гал дахин дүрэлзэн асав. БНХАУ-ын “Арктикт ойрхон улс” гэсэн тодорхойлолт нь тус бүс нутгийг цэргийн стратеги талаас харж байна уу эсвэл гагцхүү эдийн засгийн эрх ашгийн хүрээнд ийнхүү Хойд мөсөн далайн зүг хараа сунгав уу гэдэг нь одоогоор таамаг төдий байгаа ч алсдаа олон улсын байдал улам эрчимжихийн хэрээр тодорхой болох нь дамжиггүй. Юутай ч БНХАУ-ын хувьд Арктикийн бүсэд аль нэг улстай

<sup>34</sup> The White House (2013). National Strategy for the Arctic Region

нутаг дэвсгэрийн маргаан байхгүй, тиймдээ ч тус улсын Өмнөд Хятадын тэнгист явуулж буй бодлогоос эрс өөр буюу аядуу зөөлөн маягаар “Мөсөн торгоны зам” бодлогоо эхлүүлж байгаа нь Арктикийн гишүүн орнууд болон ашиг сонирхол бүхий улс орнуудын хувьд бүр ч их сэжиг таамаг дагуулж байгаа нь ойлгомжтой.

Европын холбоо болон Арктикийн зөвлөлийн улс орнууд 2013 оноос өмнө дэлхийн дулаарлын эсрэг, хүлэмжийн хийг бууруулах төсөл хөтөлбөрүүд болон Арктикийн бүс нутгийн уугуул оршин суугчдын эрх ашгийг хамгаалах, байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг ханган ажиллах хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаж байлаа. Гэтэл БНХАУ хөгжлийн стратегиа 2013 онд “Бүс ба зам” санаачилгын дагуу төсөөлсөн бөгөөд энэхүү санаачилгын хүрээнд “Мөсөн торгоны зам” гэхийн сацуу “Арктикт ойрхон улс” гэж тодорхойлон ОХУ-тай хамтын ажиллагаагаа олон талаар өргөжүүлж, Арктикийн зөвлөлийн улс орнуудад хөрөнгө оруулалт их хэмжээгээр хийх болсон зэрэг нь цаашид энэ хоёр улс тус бүс нутагт өөрийн нөлөөллийн бүс болгохын төлөөх өрсөлдөөнд оройлон оролцох боломжийг бий болгосон.

Энэ мэт нөхцөл байдал нь НАТО болон АНУ-ын хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхэд хүргэсэн нь тодорхой. Үүгээр зогсохгүй Арктикийн зөвлөлийн улс орнууд Арктикийн бүс нутгийн талаархи стратегиа шинэчлэн батлах шаардлага ч мөн бий болсон. Ингээд цаашид энэ бүс нутагт хүчний тэнцвэрийг бий болгохын тулд АНУ ба Канадын усан замын маргаан, эдийн

засгийн ач холбогдол бүхий, байгалийн асар их баялаг нөөц агуулсан далайн гүнд орших Ломоносовын нурууны хил хязгаарын маргаан зэргийг маш яаралтай шийдвэрлэх, НАТО-ийн эвсэл Гренландын аюулгүй байдал, НАТО-ийн гишүүн орны баглан хамгаалахын зарим асуудал, цэрэг, хөрөнгө оруулалтын нөхцөлөө эргэн харах зэрэг шийдэхэд төвөгтэй, ээдрээтэй нөхцөл байдал бий болж байна. АНУ Арктикийн бүс нутагт дээд зэргээр анхаарлаа хандуулах болсныг шинээр дахин сонгогдсон Д.Трампын мэдэгдлүүдээс таамаглаж болох юм. Магадгүй АНУ нь Канад, Гренландыг өөртөө нэгтгээд Панамын сувгаас БНХАУ хөрөнгө оруулалтаар дамжуулан авсан нөлөөллийг буруулж хяналтандаа авч чадаж гэмээ нь Арктикийн бүс нутагт ОХУ-тай өрсөлдөхүйц хүч бүрдүүлж чадах биз ээ. Гэвч одоогийн байдлаар бол нөхцөл байдал эсрэгээрээ буюу БНХАУ, ОХУ-ын Арктик дахь эрдэм шинжилгээ, байгаль цаг уур, эдийн засгийн хамтын ажиллагаа улам бүр далайцтай, илүү эрчимтэйгээр урагшилж байна.

Эдгээр асуудлуудыг нэгтгэн дүгнэхэд:

1. Арктикийн стратегийн ач холбогдол цаашид улам өсөн нэмэгдэнэ.
2. Геополитикийн өрсөлдөөн энэ бүс нутагт улам ширүүснэ
3. Тус нутагт цэрэг, зэвсэгийн асар их бөөгнөрөл бий болох хандлагатай байна
4. Үүсээд буй нөхцөл байдлыг зохицуулах, халалтыг зогсооход олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрүүд, өндөр дээд

хэмжээний уулзалтууд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Дэлхийн эдийн засгийн хөгжил, аж үйлдвэржилт өсөн нэмэгдэхийн хэрээр дэлхийн цаг уурын дулаарал нэмэгдэж байгаа нь; Арктикийн бүс нутагт байгаа газрын ховор элемент, байгалийн хий, газрын тос зэрэг ашигт малтмалын ордыг эзэмших; улам бүр эрчээ авч буй олон улсын худалдааны дайн; цаг уурын өөрчлөлт зэргээс

хамааралтай шинээр төлөвлөж буй далайн замуудыг эдийн засаг, цэрэг стратегийн зориулалтаар эзэмшихийн төлөөх Их гүрнүүдийн тоглолтыг эрчимжүүлж байгаа нь холбогдох Арктикийн бүсийн улс орнууд болон олон улсын байгууллага хоорондын гэрээ хэлэлцээрүүдэд тодотгол хийх бодит шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бөгөөд даруй шийдвэрлэвэл зохих асуудал болсон байна.

## Ном зүй / References:

1. Никулин, М. А. “Великодержавная конкуренция в Арктике: геополитическое соперничество в новом политическом пространстве.” *Вестник РУДН. Серия Международные отношения* 19, no. 3 (2019): 393. <http://journals.rudn.ru/international-relations>.
2. Tiggesbäumke, Günter. “Mitteilungen. Carl Weyprecht 1838–1881.” *Polarforschung* 51, no. 2 (1981): 213–218.
3. *Österreichisch-Kaiserlicher Hof-Kalender für das Jahr 1875*. Druck und Verlag der K. K. Hof- und Staatsdruckerei, 1875.
4. *Hof- und Staats-Handbuch der Österreichisch-Ungarischen Monarchie für 1877*. Druck und Verlag der K. K. Hof- und Staatsdruckerei, 1877.
5. Bellot. *Journal d'un voyage aux mers polaires exécuté à la recherche de Franklin*. Paris, 1854.
6. “Вестник НКВД”, 1921, no. 5–6.
7. Аксель, Альман. *Борьба за северный и южный полюс*. Перев. Дьяконовых. Ленинград, 1930.
8. *Tudor Economic Documents*. Vol. II. London, 1924, 19–23.
9. Фененко, А. В. “Военно-политические аспекты российско-американских отношений в Арктике: история и современность.” *Вестник Московского университета. Серия 25. Международные отношения и мировая политика* no. 2 (2011): 129–154.
10. Méndez, Fernando, and Edward Alden. “China in Panama: From Peripheral Diplomacy to Grand Strategy.” 2019.
11. Cordesman, Anthony H. *China's Maritime Strategy and Security*. Washington, D.C.: CSIS, 2019.
12. Rolland, Nadège. “China's Arctic Ambitions and the Implications for Global Geopolitics.” *The National Bureau of Asian Research* 38, no. 2 (2017): 99–118.
13. Méndez, Fernando, and Edward Alden. “China's Growing Presence in Greenland and the Arctic: Strategic and Economic Interests.” *Global Affairs Journal* 22, no. 3 (2019): 45–61.
14. Brady, Anne-Marie. *China as a Polar Great Power*. Cambridge: Cambridge University Press, 2017.
15. Humpert, Malte. “China's Polar Silk Road and the Arctic Geopolitics.” *Arctic Yearbook* (2020): 67–88.
16. Pincus, Rebecca, and David VanderZwaag. “Arctic Geopolitics and International Relations: The Future of Cooperation in a Changing Region.” *Arctic Review on Law and Politics* 9, no. 2 (2018): 23–45.
17. Liu, Nengye, and Aki Wilkman. “China's Role in Arctic Energy Development.” *Energy Policy* 147 (2021): 112–128.

18. Konyshv, Valery, and Alexander Sergunin. "Russia's Arctic Strategy: Military and Political Dimensions." *The Journal of Eurasian Studies* 12, no. 1 (2021): 55–72.
19. Humpert, Malte. "Russia's Arctic Strategy and the Future of the Northern Sea Route." *Arctic Yearbook* (2020): 45–68.
20. Pincus, Rebecca. "Three-Way Power Struggle: The US, Russia, and China in the Arctic." *Arctic Review on Law and Politics* 9, no. 2 (2018): 45–63.
21. Kremlin.ru. "Спуск на воду атомного подводного крейсера "Пермь". Accessed June 18, 2025. <http://www.kremlin.ru/events/president/news/76556>.
22. Gabuev, Alexander. "Sino-Russian Relations and Arctic Governance: Cooperation or Competition?" Carnegie Moscow Center, 2020.
23. Konyshv, Valery, and Alexander Sergunin. "Russia's Arctic Strategy and International Territorial Disputes." *The Journal of Eurasian Studies* 12, no. 1 (2021): 45–67.
24. Lanteigne, Marc. "Arctic Geopolitics after Ukraine: Russia's Role and Western Responses." *Polar Journal* 10, no. 2 (2022): 102–121.
25. Lanteigne, Marc. *The Politics of Arctic Sovereignty: Oil, Ice, and Inuit Governance*. Toronto: University of Toronto Press, 2019.
26. Wikipedia. "Питүффик (Pituffik Space Base)." Last modified 2009. <https://ru.wikipedia.org/wiki>.
27. Byers, Michael. "International Law and the Northwest Passage: Canada's Legal Position and Global Reactions." *Journal of Arctic Affairs* 8, no. 3 (2021): 102–120.
28. Huebert, Rob. "Canada and the Arctic: NATO, NORAD, and the Growing Security Challenges." *Canadian Foreign Policy Journal* 27, no. 2 (2020): 89–105.
29. Lanteigne, Marc. "China's Emerging Role in the Arctic: The Polar Silk Road and Its Implications for Canada." *Polar Journal* 9, no. 1 (2020): 78–95.
30. Lindahl, Karin. "Mining, Sustainability, and Sweden's Arctic Policy." *Journal of Arctic Studies* 15, no. 2 (2021): 78–92.
31. Ingimundarson, Valur. "Iceland and Arctic Geopolitics: Economic Interests and Security Challenges." *Journal of Arctic Affairs* 17, no. 2 (2020): 89–104.
32. Government of Iceland. *Iceland's Arctic Policy: Sustainable Development and Security in the Arctic Region*. Ministry for Foreign Affairs, 2021.
33. Department of Defense. *Arctic Strategy*. U.S. Department of Defense, 2019.
34. The White House. *National Strategy for the Arctic Region*. Washington, D.C.: The White House, 2013.



## Geostrategy of the Arctic: Great Power Rivalry and Prospects for the Future

**Chuluundorj Sundui**

*National Defense University,  
Ulaanbaatar, Mongolia  
marketpedia.mn@gmail.com*

**Ganbat Nyamdag\***

*Ph.D., Professor  
Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia  
ganbatn@mas.ac.mn*

**Abstract:** *The Arctic region encompasses the northern parts of Eurasia and North America, the Arctic Ocean (excluding the Norwegian coastal islands), and small portions of the Pacific and Atlantic Oceans. The southern boundary of the Arctic roughly coincides with the southern limit of the tundra zone. The area of this region is approximately 27 million km<sup>2</sup>, although some sources define the Arctic as the area north of the Arctic Circle (66°33'N), in which case its total area is about 21 million km<sup>2</sup>. As a result of rapid advances in civilization, technology, and industrialization, the phenomenon of a “greening Arctic” is emerging, revealing both opportunities to exploit the region’s natural resources and the opening of new maritime routes in the northern seas. These developments are key factors increasing global attention to the Arctic and enhancing its strategic value and importance.*

**Keywords:** *Arctic regional security, The Arctic Council, great power interests, rivalry*

<i>The date of submission:</i>	2025.02.10
<i>Completion of review:</i>	2025.05.14
<i>Final decision for acceptance:</i>	2025.06.16

---

\* Corresponding author